



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 8/109

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 6,905,613.00 (зургаан сая есөн зуун таван мянга зургаан зуун арван гурван) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу тухайн байгууллагын балансад шилжүүлэн данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (Л.Жаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг (Б.Алтаннавч)-т зөвшөөрсүгэй.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500719



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны дугаар сарын 11-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Цаашид ашиглах хугацаа /жил/	Үнэ шинэчлэн тогтоосон үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Принтер	Samsung 2070	2018.12.31	ширхэг	1	440,000.00	440,000.00	440,000.00	-	2	110,000.00	Баянгол
2	Хувилагч	bizhb 195	2015.01.30	ширхэг	1	2,870,000.00	2,870,000.00	2,870,000.00	-	2	717,500.00	дүүргийн 94
3	Суурин	comwin LG	2018.05.31	ширхэг	1	2,024,000.00	2,024,000.00	2,024,000.00	-	2	506,000.00	дүгээр
4	Суурин	Dell	2019.12.31	ширхэг	1	1,571,613.00	1,571,613.00	1,571,613.00	-	2	392,903.25	цэцэрлэг
		Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн				6,905,613.00	6,905,613.00	6,905,613.00	-		1,726,403.25	